



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “хөрөнгийн үнэлгээ хийх,” гэснийг, мөн зүйлийн 9.5 дахь хэсгийн “хөрөнгийн үнэлгээ,” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР